

БАТЛАВ:
ЗАХИАЛАГЧ:
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.БАТБОЛД

БАТЛАВ:
НИЙЛҮҮЛЭГЧ:
“ВЕРТЕКСМОН” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.МЭНДСАЙХАН

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 182

Улаанбаатар хот


Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө -11, Засгийн газрын 13 дугаар байр, зип:14251 хаягт байрлах, Улсын бүртгэлийн 9070005149 тоот гэрчилгээтэй, 5634768 тоот регистрийн дугаартай “Зам, тээврийн хөгжлийн яам”/цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Төрийн захиргаа удирдлагын газрын дарга Б.Болор-Эрдэнэ, нөгөө талаас Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Их Монгол улсын гудамж, Тайм Скүэр цогцолбор 511-ICT-mall хаягт байрлах, Улсын бүртгэлийн 9011348093, Регистрийн 5602513 дугаартай “ВЕРТЕКСМОН” ХХК /цаашид “Нийлүүлэгч” гэх/ түүнийг төлөөлж Бизнес хөгжлийн менежер Л. Гантулга нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дугаар зүйлийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг /цаашид “Гэрээ” гэх/ байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээгээр Нийлүүлэгч нь гэрээний Хавсралт №1-д заасан тоног төхөөрөмжүүд (цаашид “Бүтээгдэхүүн” гэх)-ийг холбогдох баримт бичгийн хамт Захиалагчид акт үйлдэн хүлээлгэн өгч, өмчлөлд нь шилжүүлэх, Захиалагч уг Бүтээгдэхүүний үнийг Нийлүүлэгчид гэрээнд заасны дагуу төлж барагдуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Талууд худалдаж авах Бүтээгдэхүүний тоо, хэмжээ, нэг бүрийн үнэ зэрэг мэдээллийг энэхүү Гэрээний Хавсралт №1-д заасны дагуу харилцан тохиролцов.

Хоёр. Гэрээний үнэ, төлбөр төлөх нөхцөл

- 2.1 Гэрээний нийт үнэ нь 18,032,400₮ (арван найман сая гучин хоёр мянга дөрвөн зуун төгрөг) бөгөөд энэхүү үнэнд замын зардал, онцгой албан татвар, НӨАТ, болон бусад холбогдох бүхий л зардал, татвар хураамж болон суурилуулалтын зардал орсон болно. Захиалагч нь гэрээний үнийг 50% буюу 9,016,200 /есөн сая арван зургаан мянга хоёр зуун төгрөг / -ийг 2022 оны тавдугаар сарын 25 -ны өдөр урьдчилан төлнө.
- 2.2 Дундын санхүүжилт болох 30% буюу 5,409,720 /Таван сая дөрвөн зуун есөн мянга долоон зуун хорин төгрөг/ -ийг Бараа материалын хүлээлгэж өгснөөр шилжүүлнэ.
- 2.3 Сүүлийн төлбөр болох 20% буюу 3,606,480 /гурван сая зургаан зуун зургаан мянга дөрвөн зуун наян төгрөг/ -ийг ажил хүлээлцэх акт үйлдсэнээр төлнө.
- 2.4 Гэрээний 2.1, 2.2, 2.3 - т заасан төлбөрийг шилжүүлэх санхүүгийн үндсэн баримт нь нэхэмжлэх байх бөгөөд Нийлүүлэгчийн Хас банкны 5002411886 тоот дансанд төлнө.



- 2.5 Нийлүүлэгч нь бүтээгдэхүүн шилжүүлэхтэй холбогдсон /савлах, баглах гэх.мэт/ зардал болон бүтээгдэхүүнийг захиалагчийн байгаа газарт хүргэх (Улаанбаатар хот дотор), зөөх, тээвэрлэх, хүлээн авахтай холбогдсон зардлыг бүрэн хариуцна.
- 2.6 Гэрээний хугацаанд бүтээгдэхүүний үнэд өөрчлөлт орох, мөнгөний ханш өөрчлөгдөх, мөнгөн масштабт өөрчлөлт орсон нь бүтээгдэхүүний нийт үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.


**Гурав. Бүтээгдэхүүнд тавигдах шаардлага,
хүлээлгэн өгөх, ажил гүйцэтгэх хугацаа, журам**

- 3.1. Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэх Бүтээгдэхүүн нь Хавсралт №1-д заасан загвар, тоо ширхэг, үнэ, чанарын болон бусад шаардлагыг бүрэн хангасан байна.
- 3.2. Нийлүүлэгч нь Захиалагчид бүтээгдэхүүнийг энэхүү гэрээний дагуу төлбөрийг төлсөн өдрөөс хойш ажлын **70** хоногт бараа нийлүүлж, ажлын **10** хоногт багтаан угсарч суурилуулан хүлээлгэн өгнө.
- 3.3. Нийлүүлэгч бүтээгдэхүүнийг Захиалагчид Хавсралт№1-д заасан тоо ширхгээр тоног төхөөрөмж хүлээлцэх акт үйлдэн албан ёсоор хүлээлгэн өгнө.

Дөрөв. Баталгаат хугацаа

Бүтээгдэхүүний баталгаат хугацаа нь захиалагчид бүтээгдэхүүнийг албан ёсоор акт үйлдэж хүлээлгэн өгснөөс хойш– **12 сар** байна.

- 4.1 Дараах гэмтлүүд баталгаат хугацаанд хамаарахгүй. Үүнд:
- 4.1.1. Бусад газар засвар хийлгэсэн,
- 4.1.2. Дотор нь гадны биет, бодис, ус, шингэн, шавьж хорхой орсноос үүдсэн гэмтэл,
- 4.1.3. Цахилгааны хэлбэлзэл, гал түймэр болон бусад гамшгаас учирсан гэмтэл,
- 4.1.4. Гадна болон дотор эд ангийн бүх төрлийн механик гэмтэл,
- 4.1.5. Компаниас бараа худалдаж авахад урамшуулал болгон олгосон бараа.
- 4.1.6. Лац хөндсөн, гадны механик болон цахилгааны хэлбэлзлээс болсон гэмтэл.
- 4.3. Дараах тохиолдлуудад баталгаат хугацааг хүчингүйд тооцож засвар үйлчилгээ хийхгүй. Үүнд:
- 4.3.1. Лац хөндөгдсөн, хөдөлгөж гэмтээсэн,
- 4.3.2. Баталгаат засварын хуудсыг засварласан, дурайлган үйлдсэн,
- 4.3.3. Баталгаат засварын хуудсыг хаяж үрэгдүүлсэн,
- 4.3.4. Баталгаат засварын хугацаа дууссан.
- 4.4. Баталгаат хугацаанд засварын газраар үйлчлүүлэхдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд:
- 4.4.1. Баталгаат хуудас, зарлагын баримтыг бүтээгдэхүүний хамт авчрах,
- 4.4.2. Барааг авч ирэхдээ өөрийнх нь сав, баглаа боодолтой, анхны иж бүрдлээр нь авчирна.
- 4.4.3. Барааны тоос шороо, хүнсний үлдэгдэл, тос зэргийг сайтар цэвэрлэсэн байна.
- 4.4.4. Гэмтэлтэй барааг засварын төвд хүргэх болон авах аливаа тээврийн зардлыг үйлчлүүлэгч өөрөө хариуцна.
- 4.5. Баталгаат хугацаа дууссан тохиолдолд энэхүү гэрээнд заасан аливаа гомдлыг захиалагч гаргах эрхгүй.
- 4.6. Баталгаат хугацаанд бүтээгдэхүүний гэмтлийг засварлах хугацаа 30 хүртэл хоног байна.



Тав. Нийлүүлэгчийн эрх, үүрэг

- 5.1. Нийлүүлэгч дараах үүргийг хүлээнэ:
- 5.1.1. Нийлүүлэгч тал нь Захиалагчид бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх;
 - 5.1.2. Бүтээгдэхүүнийг Захиалагчийн өмчлөлд шилжүүлэхтэй холбогдон гарах / савлах, баглах гэх.мэт/ зардал болон барааг нийлүүлэгчийн байгаа газарт (Улаанбаатар хот дотор) хүргэх, зөөх, тээвэрлэх, хүлээлгэн өгөхтэй холбогдсон зардлыг бүрэн хариуцах;
 - 5.1.3. Захиалагчийн захиалсан бүтээгдэхүүний загвар, тоо ширхэг, үнэд Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахгүй байх;
 - 5.1.4. Нийлүүлэгчийн нөөц хүрэлцэхгүй болсон тохиолдолд захиалагчийн зөвшөөрөлтэйгөөр бүтээгдэхүүний загвар, тоо ширхэгт өөрчлөлт оруулах;
- 5.2. Нийлүүлэгч дараах эрхийг эдэлнэ:
- 5.2.1. Энэхүү гэрээний дагуу нийлүүлж буй бүтээгдэхүүнийг хүлээж авах эсхүл бүтээгдэхүүний төлбөрийг төлөхөөс Захиалагч үндэслэлгүйгээр татгалзвал үүнээс үүдэн өөрт учирсан зардал, хохирлыг төлүүлэхээр Захиалагчаас шаардах;
 - 5.2.2. Бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг Захиалагчаас шаардах,
 - 5.2.3. Энэхүү гэрээнд заасан хугацаанд бүтээгдэхүүний төлбөрийг төлөхийг Захиалагчаас шаардах,
 - 5.2.4. Захиалагч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас өөрт учирсан хохирол, зардлыг нөхөн төлүүлэхээр шаардах,
 - 5.2.5. Захиалагчийг гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах,
 - 5.2.6. Захиалагчийн захиалсан бүтээгдэхүүний загвар, тоо ширхэг, үнэд Захиалагчийн зөвшөөрлөөр өөрчлөлт оруулах.

Зургаа. Захиалагчийн эрх, үүрэг

- 6.1. Захиалагч нь дараах үүргийг хүлээнэ:
- 6.1.1. Энэ Гэрээнд заасан хугацаанд биет байдлын болон эрхийн доголдолгүй бүтээгдэхүүнийг шалгаж, тоног төхөөрөмж хүлээлцэх актаар хүлээн авах,
 - 6.1.2. Гэрээнд заасан хугацаанд бүтээгдэхүүний төлбөрийг төлөх,
 - 6.1.3. Энэхүү гэрээний дагуу нийлүүлж буй бүтээгдэхүүнийг хүлээж авах буюу бүтээгдэхүүний төлбөрийг төлөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас гэрээнд заасан хугацаанд бүтээгдэхүүнийг хүлээн аваагүйтэй холбоотойгоор Нийлүүлэгч талд учирсан зардал, хохирлыг нөхөн төлөх;
 - 6.1.4. Гэрээнд заасан хохирол, алданги, зардлыг үл маргах журмаар төлөх,
 - 6.1.5. Бүтээгдэхүүнийг зааврын дагуу ашиглах,
 - 6.1.6. Энэ Гэрээ болон хуульд заасан бусад үүрэгийг хүлээнэ.
- 6.2. Захиалагч дараах эрхийг эдэлнэ:
- 6.2.1. Бүтээгдэхүүн ашиглалтын явцад илэрсэн чанарын дутагдлын талаар Нийлүүлэгчид гомдол гаргах, үүнээс үүдэн учирсан хохирлыг шийдвэрлэхэд хамтран ажиллах,
 - 6.2.2. Нийлүүлэгчийн нийлүүлсэн бүтээгдэхүүн нь биет байдлын болон эрхийн доголдолтой нь тогтоогдсон тохиолдолд уг доголдлыг арилгуулах (засварлуулах), доголдлыг арилгах боломжгүй тохиолдолд тухайн төрлийн ижил бүтээгдэхүүнээр солиулж авах.

Долоо. Холбоо, харилцаа

- 7.1. Гэрээнд холбогдох асуудлаар Талууд дараах байдлаар харилцахыг албан ёсны харилцаа хэмээн үзнэ.
7.1.1. Албан бичгээр,
7.1.2. Албаны цахим шуудангаар тус тус харилцана.
7.1.3. Дараах хаягуудыг албан ёсны харилцах хаяг хэмээн тооцно.

Нийлүүлэгчийн харилцах хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Их Монгол улсын гудамж, Тайм Скүэр цогцолбор 511-ICT-mall
Цахим шуудан: gantulga@vertexmon.com
Утас: 97110064

Захиалагчийн харилцах хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө -11, Засгийн газрын 13 дугаар байр, зип:14251
ТЗУГ-ын мэргэжилтэн: Б. Гүнхичээнгүй
Цахим шуудан: gunkhicheengui@mrt.d.gov.mn
Утас: 95508558

Найм. Харнуцлага

- 7.1. Нийлүүлэгч энэхүү гэрээнд заасан хугацаанд бүтээгдэхүүнийг Захиалагчид нийлүүлээгүй тохиолдолд Нийлүүлэгч Гэрээний гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,1 хувийн алдангийг Захиалагчид төлнө.
7.2. Захиалагчэнэ Гэрээний 2.1-г заасан хугацаанд бүтээгдэхүүний төлбөрийг Нийлүүлэгчид төлөөгүй бол Захиалагч нь төлөөгүй төлбөрийн үнийн дүнгээс хоног тутамд 0,1 хувийн алдангийг Нийлүүлэгчид төлнө.
7.3. Талуудын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол үүнээс үүдэн нөгөө талд учирсан хохирол, зардлыг бүрэн хариуцаж барагдуулна.

Ес. Нууцын баталгаа

- 9.1. Талуудад энэ гэрээ байгуулснаар мэдэх болсон нөгөө талынхаа үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар ашиглах болон гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

Арав. Давагдашгүй хүчин зүйл.

- 10.1. Холбогдох хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын тав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
10.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
10.3. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.
10.4. Гэрээг хэрэгжүүлэх явцад давагдашгүй хүчин зүйлийн улмаас нөгөө талдаа учирсан хохирлыг Талууд хариуцан хүлээхгүй.

Арван нэг. Маргаан шийдвэрлэх

- 11.1. Гэрээтэй холбогдон үүсэх аливаа маргаантай асуудлыг талууд эвийн журмаар зохицуулахыг эрмэлзэх бөгөөд боломжгүй нөхцөл байдал үүсвэл Монгол Улсын шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

Арван хоёр. Бусад зүйл

- 12.1. Гэрээ нь Талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсгээ зурж, тамга тэмдгээ дарснаар хүчин төгөлдөр болно.
- 12.2. Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.
- 12.3. Талууд гэрээнд заасан үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн тохиолдолд нэг талын санаачилгаар гэрээг цуцалж болно.
- 12.4. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа 7-оос доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.
- 12.5. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Талууд харилцан тохиролцож, бичгээр хийх бөгөөд аман байдлаар тохирсон тохиолдолд гэрээний үүрэг хэмээн тооцохгүй.
- 12.6. Нийлүүлэгч тал нь нууцын зэрэглэлгүй мэдээ мэдээлэл, хийсэн ажлаа маркетингийн сувгаар ашиглаж болно.

Гэрээ байгуулсан:

Захиалагчийг төлөөлж:

Төрийн захиргааны удирдлагын
газрын дарга

.....
Б.Болор-Эрдэнэ

Санхүү хөрөнгө оруулалтын
хэлтсийн шинжээч

.....
Г.Алтангэрэл

Мэдээллийн технологи, стандартын
хэлтсийн дарга

.....
Э.Мөнхнасан

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

.....
Б.Цэнд

ТЗУГ-ын мэргэжилтэн

.....
Б.Гүнхичээнгүй

Нийлүүлэгчийг төлөөлж:

“ВЕРТЕКСМОН” ХХК-ИЙН
Гүйцэтгэх захирал

.....
Д.МЭНДСАЙХАН

“ВЕРТЕКСМОН” ХХК-ИЙН
Байгууллагын бизнесийн албаны
захирал

.....
Б.ЭНХ-АМАР

“ВЕРТЕКСМОН” ХХК-ИЙН
Байгууллагын бизнесийн албаны
Бизнес хөгжлийн менежер

.....
Л. ГАНТУЛГА



Гэрээний дугаар	Огноо	Талууд гарын үсэг зурах		Хуудас 5 / 8
	202.05.25	Нийлүүлэгч:	Захиалагч:	

ЗТХЯ-ны хяналтын камер суурьлуулах ажлыг хүлээлцсэн тухай

ТТХ-ын газраас ирүүлсэн шаардлагын дагуу тус яамны хяналтын камерыг солих болон шинээр суурьлуулах ажил 6 дугаар сарын 13 ны өдрөөс эхлэн 3 долоо хоногийн хугацаанд “ВЕРТЕКСМОН ХХК” хийж гүйцэтгэв. Тус ажил үнийн саналд тусгагдсан тоног төхөөрөмжийн дагуу камер болон серверийн хүчин чадал нь зөрсөн зүйлгүй байна. Нийт 20ш камерийг тус компани суурьлуулсан ба өнцгийн тохиргоо системийн аюулгүй байдал зэрэг асуудлыг бүрэн шийдэж гэрээнд тусгагдсан үүргээ биелүүлсэн тул үлдэгдэл төлбөрийг төлөхөд татгалзах зүйлгүй. Суурьлуулсан төхөөрөмжүүдийг хавсаргав.



Нийлүүлэгч талыг төлөөлж:

“ВЕРТЕКСМОН” ХХК-ийн
Байгууллагын бизнесийн албаны
Бизнес хөгжлийн менежер

Л.Гантулга

Л.Гантулга

“ВЕРТЕКСМОН” ХХК-ийн

Ахлах инженер

З.Ууганбаяр

З.Ууганбаяр -г

Захиалагч талыг төлөөлж:

Төрийн захиргааны удирдлагын
газрын дарга

Б.Болор-Эрдэнэ

Б.Болор-Эрдэнэ

Мэдээлэл технологи стандартын
хэлтсийн мэргэжилтэн

Э.Шаарийбуу

Э.Шаарийбуу

Төрийн захиргааны удирдлагын

газрын мэргэжилтэн

Б.Гүнхичээнгүй

Б.Гүнхичээнгүй

2022.07.04